



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/108/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: bat-undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506


Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитор: Б.Мөнхнасан

Утас: 90066888

Цахим хаяг: munkhnasanb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



1.ХАРААТ АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улаанстай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Л.ОДОНТУЯА-д

2024.03.25 № 264

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газар 7,259.4 мянган төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлтэй холбоотой 133,018.1 мянган төгрөгийн, Орон нутгин хөгжлийн сангийн үйл ажиллагаатай холбоотой 37,494.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил тус тус илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны

журам"-ын 3.4-т "Сум дүүргийн Засаг даргын чиг үүрэг", 3.4.3-т "Сум, дүүргийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих", "Сум дүүргийн Засаг даргын чиг үүрэг", 3.4.3-т "Сум, дүүргийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.3. "энэ журмын 3.4.2-т заасан төслийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэнтэй холбогдох хууль, журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, төслийн явц, үр дүнд байнгын хяналт тавих", 3.4.11 "Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн бөгөөд сумын Засаг дарга Төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдэлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны санхүүжилтийг өмнөх онтой харьцуулахад 3,821,710.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь татвар болон татварын бус орлого 385,946.8 мянган төгрөгөөр, тус онд цалин нэмэгдсэнтэй холбогдуулан орон нутгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 3,047,863.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн болон улсын төсөвт байгууллагын тогтмол зардал зэрэг бусад зардал өссөнтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитын хүрээнд харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийхэд сумын Засаг даргын үйл ажиллагаатай шууд хамааралтай алдаа, зөрчил өмнөх оноос 18,8 хувиар буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тосонцэнгэл сумын Засаг дарга нь тайлант онд татварын орлогыг 1,594,042.3 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 1,496,858.8 мянган төгрөг буюу 6,0 хувиар буурсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР





2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	985,479.2	1,040,753.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	386,057.4	205,082.7
33	АВЛАГА	524,174.1	696,109.1
35	БАРАА МАТЕРИАЛ	75,247.7	139,561.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,294,840.4	3,454,746.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,294,840.4	3,454,746.1
39200	Биет хөрөнгө	1,631,362.4	2,787,237.2
39300	Биет бус хөрөнгө	663,478.0	667,508.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,280,319.6	4,495,499.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,092.4	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,092.4	0.0
41300	Өглөг	1,092.4	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,279,227.3	4,495,499.1
51	Засгийн газрын хувь оролцоо	3,279,227.3	4,495,499.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	900,765.3	900,765.3
51200	Хуримтлагдсан үр дүн	2,284,080.3	3,500,352.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	94,381.6	94,381.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,280,319.6	4,495,499.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,709,669.2	5,997,439.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,110,912.0	1,496,858.8
110	Орлогын албан татвар	786,348.3	1,123,051.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	880,155.2	1,244,975.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-93,806.9	-121,923.8
113	Хөрөнгийн албан татвар	86,704.7	87,344.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	237,858.9	286,462.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	928,254.0	1,855,000.8
120	Нийтлэг татварын бус орлого	928,254.0	1,855,000.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,670,503.2	2,645,580.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,498,797.6	3,387,048.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,498,797.6	3,387,048.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	979,731.0	2,886,816.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	443,973.0	665,354.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,459.6	83,974.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,333.9	54,590.7
2104	Хангамж, бараа материалын зардал	49,593.2	64,078.2
2105	Нормативт зардал	5,673.0	396.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,718.6	13,533.2
2107	Томилолт, зочны зардал	8,230.0	13,706.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,060.1	163,803.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	201,689.5	1,827,378.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,519,066.6	500,232.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,210,871.7	2,610,391.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	14,652,683.8	1,394,119.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-13,441,812.1	1,216,271.8



2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/


Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,468,369.0	16,468,369.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	252,670.4	252,670.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,721,039.4	16,721,039.4
9	Тайлант үеийн үр дүн	-13,441,812.1	-13,441,812.1
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,279,227.3	3,279,227.3
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,279,227.3	3,279,227.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,279,227.3	3,279,227.3
19	Тайлант үеийн үр дүн	1,216,271.8	1,216,271.8
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,495,499.1	4,495,499.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,236,011.6	4,660,809.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,110,912.0	1,496,858.8
110	Орлогын албан татвар	786,348.3	1,123,051.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	880,155.2	1,244,975.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-93,806.9	-121,923.8
113	Хөрөнгийн албан татвар	86,704.7	87,344.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	237,858.9	286,462.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	53,363.6	36,595.8
1181	Газрын төлбөр	10,044.9	54,088.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	174,450.4	195,778.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	417,781.4	518,370.6
120	Нийтлэг татварын бус орлого	417,781.4	518,370.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,707,318.2	2,645,580.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,375,828.7	3,121,177.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,375,828.7	3,121,177.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	856,762.1	2,620,945.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	442,207.6	665,255.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,281.0	84,060.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,661.9	54,689.1
2104	Хангамж, бараа материалын зардал	48,852.2	56,024.2
2105	Нормативт зардал	5,673.0	396.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,929.6	14,955.2
2107	Томилолт, зочны зардал	8,230.0	13,706.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	120,605.9	161,640.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,320.9	1,570,216.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,519,066.6	500,232.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	860,182.8	1,539,631.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	610,292.8	1,627,150.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	610,292.8	1,627,150.6
2200	Дотоод эх үүсвэрээр	610,292.8	1,627,150.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-610,292.8	-1,627,150.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-150,000.0	-93,455.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР	150,000.0	93,455.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	99,890.1	-180,974.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	286,167.3	386,057.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	386,057.4	205,082.7



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,621,103.8	4,301,505.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,669,173.1	2,593,256.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,636,919.1	2,561,002.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	674,272.5	662,828.2
210101	Үндсэн цалин	503,246.4	450,473.2
210102	Нэмэгдэл	146,716.4	176,160.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,815.0	1,815.0
210104	Урамшуулал	22,494.7	31,547.9
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	2,831.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,366.8	83,860.8
210201	Тэтгэврийн даатгал	57,689.5	57,100.3
210202	Тэтгэмжийн даатгал	6,669.3	6,741.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,335.5	5,477.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,333.8	1,321.3
210205	Эрүүл мэндийн даатгал	13,338.7	13,220.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,396,985.6	1,343,557.6
210301	Гэрэл, цахилгаан	115,975.2	90,757.4
210302	Түлш, халаалт	1,204,814.5	1,180,170.3
210303	Цэвэр, бохир ус	76,195.9	65,629.9
210304	Байрны түрээс	0.0	7,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	51,425.8	50,214.5
210401	Бичиг хэрэг	7,891.0	9,141.0
210402	Тээвэр, шатахуун	34,512.4	35,551.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,022.4	5,522.3
2105	Нормативт зардал	396.0	396.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396.0	396.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,862.0	38,881.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000.0	4,327.2
210604	Урсгал засвар	34,862.0	34,554.7
2107	Томилолт, зочны зардал	13,014.1	12,947.7
210702	Дотоод албан томилолт	13,014.1	12,947.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,732.2	108,257.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,700.0	100,700.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	780.0	299.3
210803	Даатгалын үйлчилгээ	519.1	276.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	254.9	27.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120.8	47.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203.4	0.0
210807	Газрын төлбөр	7,138.3	6,906.6
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.7	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	262,864.1	260,058.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	262,060.7	259,408.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	803.4	650.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,254.0	32,254.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,254.0	32,254.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,254.0	32,254.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,801,930.7	1,614,793.6
223001	Бусад хөрөнгө	1,801,930.7	1,614,793.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150,000.0	93,455.6
230001	Эргэж төлөгдөх зээл	150,000.0	93,455.6

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,621,103.8	4,196,837.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,543,783.2	4,046,507.9
320001	Орон нутгийн төсвөөс	2,487,743.9	2,990,468.6
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,056,039.3	1,056,039.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,077,320.6	150,329.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,942.6	150,329.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,058,378.0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	274,226.8
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	169,558.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/


Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,300.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,465.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	69,465.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,427.4
210101	Үндсэн цалин	2,427.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	200.0
210201	Тэтгэврийн даатгал	200.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,068.4
210301	Гэрэл, цахилгаан	1,675.8
210302	Түлш, халаалт	3,392.6
2104	Хангамж, бараа материалын зардал	5,809.7
210401	Бичиг хэрэг	1,647.0
210402	Тээвэр, шатахуун	3,484.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	678.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	860.0
210604	Урсгал засвар	860.0
2107	Томилолт, зочны зардал	759.0
210702	Дотоод албан томилолт	759.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,340.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,950.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	390.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,835.0
2200	Дотоод эх үүсвэрээр	2,835.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,835.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	72,300.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	72,300.3
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,540.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	61,760.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тосонцэнгэл сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Эрхэм зорилго: Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах төрийн байгууллага, мэргэжилтэн, албан хаагч багийн Засаг дарга нарын ажлыг уялдуулан оновчтой



бодлого, зохицуулалтаар хангаж орон нутгийн хөгжлийн төлөө төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэж, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд оршино.

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 99 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 84 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тосонцэнгэл сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,215,179.4 мянган төгрөгөөр буюу 37 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	386,057.4	205,082.7	(180,974.6)
Авлага	524,174.1	696,109.1	171,934.9
Бараа материал	75,247.7	139,561.2	64,313.5
Үндсэн хөрөнгө	2,294,840.4	3,454,746.1	1,159,905.7
Нийт хөрөнгө	3,280,319.6	4,495,499.1	1,215,179.4
Өр төлбөр	1,092.4	-	(1,092.4)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,279,227.3	4,495,499.1	1,216,271.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,280,319.6	4,495,499.1	1,215,179.4



3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 205,082.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 180,974.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төгрөг			
Төрийн сангийн харилцах	386,057.4	205,082.7	(180,974.6)
Дүн	386,057.4	205,082.7	(180,974.6)

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 180,974.6 мянган төгрөгөөр буурсан нь 2022 оны давсан орлогоос аймгийн төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаа болон орон нутгийн тусгай сангуудад тавих хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 177,772.1 мянган төгрөгийн зөрчил байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 696,109.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 171,934.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	1,512.6	1,500.0	(12.6)
Байгууллагаас авах авлага	7,220.0	213,674.4	206,454.4
Хувь хүмүүсээс авах авлага	515,441.6	480,934.7	-34,506.9
Дүн	524,174.1	696,109.1	171,934.9

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өмнөх оны үлдэгдлээс 171,934.9 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-д байгууллагаас авах авлага 2013,674.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, Засаг даргын Тамгын газрын байгууллагаас авах 7,220.0 мянган төгрөгийн авлага барагдаж, Хоршоо хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага 41,507.0 мянган төгрөгөөр буурсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Авлагатай холбоотой алдаа, зөрчил илрээгүй

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данстай холбоотой үлдэгдэл тайланд тусгагдаагүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 139,561.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 64,313.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	0.0	200.0	200.0
Тусгай зориулалттай материал	0.0	200.0	200.0
Хангамжийн материал	75,247.7	139,361.2	64,113.5
Бичиг хэргийн материал	846.0	1,173.8	327.8
Аж ахуйн материал	7,731.1	8,946.1	1,215.0
Сэлбэг хэрэгсэл	0.0	2,000.0	2,000.0
Түлш, шатах тослох материал	1,978.0	2,296.4	318.4
Барилгын засварын материал	0.0	4,980.0	4,980.0
Бусад хангамжийн материал	64,530.7	120,361.2	55,830.5
Дүн	75,247.7	139,561.2	64,313.5

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 64,313.5 мянган төгрөгөөр өссөн нь сумын ОНХС-аас 105,867.5 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр, хандиваар 5,700.0 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, данс бүртгэлд тусгасан, тайлант онд 173,646.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 220,900.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Бараа материалтай холбоотой алдаа, зөрчил илрээгүй

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой бүртгэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3,454,746.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,159,905.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	1,631,362.4	2,787,237.2	1,155,874.8
Барилга, байгууламж, орон сууц	1,355,513.5	2,405,617.2	1,050,103.6
Авто-тээврийн хэрэгсэл	333,978.1	367,380.1	33,402.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	221,263.6	231,603.4	10,339.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	71,257.2	79,644.7	8,387.5
Бусад үндсэн хөрөнгө	352,504.7	495,817.2	143,312.5
Биет бус хөрөнгө	663,478.0	667,508.8	4,030.8
Программ хангамж	3,050.0	7,750.0	4,700.0
Бусад биет бус хөрөнгө	662,073.0	662,073.0	0.0
Хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	(704,799.6)	(795,139.4)	(90,339.8)
Дүн	2,294,840.4	3,454,746.1	1,159,905.7

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 1,159,905.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 12,357.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан, 610,914.9 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгө, хандиваар 664,712.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй нэмэгдсэн, 80,942.0 мянган төгрөгийн хөрөнгө дахин үнэлж бүртгэсэн, 37,739.2 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, тайлант оны элэгдлийн зардалд 209,021.0 мянган төгрөгийг тооцож, бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: ЗДТГ нь тайлант онд худалдаж авсан 11,400.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд зөв ангилж бүртгээгүй алдааг залруулсан байна.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 0.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,092.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Өр төлбөрийн үлдэгдэл


Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	1,092.4	0.0	(1,092.4)
Дүн	1,092.4	0.0	(1,092.4)

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр өмнөх оны үлдэгдлээс 1,092.4 мянган төгрөгөөр буурсан нь Хоршоо хөгжүүлэх сангийн байгууллагад төлөх өглөг барагдсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Өр төлбөртэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй



3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,495,499.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,216,271.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	900,765.3	900,765.3	0.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	900,765.3	900,765.3	0.0
Хуримтлагдсан үр дүн	2,284,080.3	3,500,352.2	1,216,271.8
Өмнөх үеийн үр дүн	15,725,892.5	2,284,080.3	-13,441,812.1
Тайлант үеийн үр дүн	-13,441,812.1	1,216,271.8	14,658,084.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	94,381.6	94,381.6	0.0
Дүн	3,279,227.3	4,495,499.1	1,216,271.8

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 1,216,271.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шууд захирагчдын төсвийн төслийг нэгтгэдэггүй байна. Шууд захирагчид тус тусдаа төсвийн төслийг боловсруулан Төсвийн ерөнхийлөн захирагчийн холбогдох хэлтэст хүргүүлэн, нэгтгүүлж байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 82 дугаар тогтоолоор Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг 4,343,048.9 мянган төгрөгөөр баталжээ. Үүнээс орон нутгийн байгууллагын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээ 3,397,044.2 мянган төгрөг байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн ... арга хэмжээг санхүүжүүлэхээр 766,357.5 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас сумд олгох орлогын шилжүүлгээс, Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал 946,004.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2,046,587.0 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 565,157.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 18,942.6 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр сумын ИТХ-аар анх баталжээ.

Аймгийн 2023 оны төсвийн тодотголоор аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 289,681.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 07 сарын 06-ны өдрийн 128 дугаар тогтоолоор 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг тодотгож, 5,018,594.5 мянган төгрөг болсон байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 1,056,039.3 мянган төгрөгийн, улсын төсөвт байгууллагын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс 1,369,540.4 мянган төгрөгийн Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 135,979.2 мянган төгрөгийн, Ойн ангийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 14,350.0 мянган төгрөгийн, татварын болон татварын бус орлогоос 1,530,623.4 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 90,304.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь батлагдсан төсвөөс 424,266.7 мянган төгрөг дутуу байна. Энэ нь ИТХ, ЗДТГ, Ойн анги, ОНХС-д санхүүжилт дутуу олгосон, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг төлөвлөдөггүй, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцсон зэрэг нь нөлөөлж байна.

д/д	Санхүүгийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	1,056,039.3	1,056,039.3	0.0



2	Улсын төсөвт байгууллагын тогтмол зардал	1,369,540.4	1,369,540.4	0.0
3	Татварын болон татварын бус орлого	1,591,757.0	1,530,623.4	61,133.6
4	Урьд оны үлдэгдэл	584,824.6	90,304.9	494,519.7
5	Үндсэн үйл ажиллагааны орлого	18,942.6	150,329.2	(131,386.6)
ДҮН		4,621,103.9	4,196,837.2	424,266.7

Татварын болон татварын бус орлогоор 1,986,824.0 мянган төгрөгийг бүрдүүлж, татварын буцаан олголтод 121,923.8 мянган төгрөгийг, санхүүжилтэд 1,530,623.4 мянган төгрөгийг олгож, 413,900.0 мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,301,505.2 мянган төгрөг буюу 93.1 хувьтай байгаа нь сумын ИТХ-ын БИНХ-ын хурал даргалагчийн урамшууллыг хэт өндөр төлөвлөсөн, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил худалдан авах зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг хэмнэсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зарим ажил хийгдээгүй, Хоршоо хөгжүүлэх сангаас төлөвлөсөн хэмжээнд зээл олгоогүй, ИТХ, ЗДТГ, Ойн анги, ОНХС-д санхүүжилт дутуу олгосон зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	147,695.0	143,937.6	3,757.4	97.5%
2	Засаг даргын Тамгын газар	985,295.2	971,806.6	13,488.6	98.6%
3	Орон нутгийн хөгжлийн сан	1,801,930.7	1,614,793.6	187,137.1	89.6%
4	Хоршоо хөгжүүлэх сан	150,000.0	93,455.6	56,544.4	62.3%
5	Улсын төсөвт байгууллагын тогтмол зардал	1,369,540.4	1,315,818.3	53,722.1	96.1%
6	Ойн анги				
ДҮН		4,621,103.9	4,301,505.2	319,598.7	93.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 72,300.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 69,465.2 мянган төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, тээвэр шатахуун, шуудан холбоо, урсгал засвар, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн


Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн



буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төсвийн шууд захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхнасан гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын Засаг дарга нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/105 дугаартай албан тоотор ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 7,531,379.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 112,970.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 84,728.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, аудитыг гүйцэтгэх шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 19 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.


4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Тосонцэнгэл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хяналт хэрэгжүүлээгүй, албан үүргээ хэрэгжүүлээгүйтэй холбоотой 371,376.6 мянган төгрөгийн зөрчилд сумын Засаг даргад сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд өгч, хэрэгжүүлж ажиллаагүй тул дараагийн шатны төсвийн захирагчид шилжүүлээ.



Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	371,376.6	-	-	0%
Зөвлөмж	-	-	-	-	-
Нийт дүн	1	371,376.6			0%

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 177,772.1 мянган төгрөгийн зөрчил илэрч 1 заалт зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 177,772.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 64,801.4 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаа болон орон нутгийн тусгай сангуудад тавих хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 177,772.1 мянган төгрөгийн зөрчил байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4-т "Сум дүүргийн Засаг даргын чиг үүрэг", 3.4.3-т "Сум, дүүргийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.3-д "энэ журмын 3.4.2-т заасан төслийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэнтэй холбогдох хууль, журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, төслийн явц, үр дүнд байнгын хяналт тавих", 3.4.11-д "Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж, холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн	
Төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаа болон орон нутгийн тусгай сангуудад тавих хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 177,772.1 мянган төгрөгийн зөрчил байна	1	177,772.1					1	177,772.1					
Дүн	1	177,772.1					1	177,772.1					

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Б.МӨНХНАСАН



Огноо: 2024-03-25

